

**ХУУЛЬ САХИУЛАГЧИЙН ХҮНИЙ ЭРХЭД
СУУРИЛСАН ШИЙДВЭР ГАРГАЛТ
HUMAN RIGHTS-BASED DECISION-MAKING
BY LAW ENFORCEMENT**

Э.Өнөболд

Дотоод хэргийн их сургуулийн Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн багш, хошууч,

Хураангуй: Хууль сахиулах байгууллагын алба хаагч нь хуулийг нэг мөр хэрэгжүүлж, сахин хамгаалахад чиглэгддэг. Харин хуулийг сахин хамгаалах чиг үүрэг нь хүний эрх, эрх чөлөөтэй хэрхэн холбогдож, хууль сахиулагч хүний эрхэд суурилсан шийдвэрийг хэрхэн гаргах боломжтойг тодорхойлохыг зорьсон.

Уг зорилгод хүрэхийн тулд өгүүллийг хууль зүйн шинжлэх ухааны норматив арга зүйд суурилан боловсрууллаа. Энэ арга зүйн хүрээнд хөгжлийн хандлагын ерөнхий агуулгыг судлан түүнд агуулагдах үзэл санааг хууль сахиулагчийн шийдвэр гаргалтад авч үзэх шалгуурууд болгох байдлаар судалгааг хийсэн.

Төрийн байгууллагын үйл ажиллагаа нь хууль хэмээх бодлогын шийдвэрт суурилах бөгөөд хуулийг боловсруулах, батлах үйл ажиллагаа болон хуулийг хэрэгжүүлэх үе шатанд төрийн албан хаагч, хууль сахиулагчаас хүний эрхийн шалгуураар шийдвэр гаргах бүрэн боломжтой болохыг дүгнэсэн.

Түлхүүр үг: Хүний эрх, хууль сахиулагч, шийдвэр, шийдвэр гаргалт, хөгжил, хандлага, алба хаагч, ач холбогдол.

Удиртгал

Хүний эрх ба хөгжил хоёр нь харилцан хамаарал бүхий үнэт зүйлс болохын хувьд учир шалтгаант холбоогоор холбогддог. Хүний эрх болон хөгжлийн хоорондын хамаарал нь Хүний хөгжлийн хандлага, НҮБ-ын Хөгжих эрхийн тунхаглал, Мянганы хөгжлийн зорилтууд, Тогтвортой хөгжлийн зорилтууд¹ зэрэг баримт бичгүүдэд тусгагдсан байдаг. Эдгээр баримт бичгүүд нь хүний эрх ба хөгжлийн хоорондын харилцан хамаарлыг чухалчлан үзэхийн хамт олон улсын болон үндэсний хөгжлийн бодлогод тусгахыг эрмэлздэг. Мөн иргэний, улс төрийн, нийгэм, эдийн засгийн болон соёлын ямар нэгэн эрхийг эдлэх боломжгүй байх нь хөгжилд тулгарч буй бэрхшээл саад мөн болохыг онцлон үзсэн байдаг. Иймд хүний эрх болон хөгжлийн хоорондын нэгдмэл чанарт үндэслэсэн эрхэд суурилан хөгжих хандлага, түүний үнэт зүйлсийг чухалчлан үзэх байдал нэмэгдэж байна.

¹ Тогтвортой хөгжлийн зорилго. НҮБ-ийн Ерөнхий Ассамблей. Женев., 2015 оны 09-р сар.

Улс орны хөгжлийг тодорхойлох хамгийн том хүчин зүйл бол шийдвэр гаргалт бөгөөд тухайн шийдвэрийн үзэл санаа, зорилго нь улс орны хөгжлийн чиг хандлага, тогтвортой хөгжлийг тодорхойлж байна.

Төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр гаргалт нь хүний эрх, хүний хэрэгцээнд тулгуурласан оновчтой, шударга байх ёстой. Бүх шатны шийдвэр гаргалт тухайн улсын хөгжлийн түвшин чиг баримжааг тодорхойлох бөгөөд дан ганц эрх барих байгууллага, бодлого боловсруулагчийн шийдвэр гаргалтыг онцлон авч үзэх нь хүний эрхэд суурилсан шийдвэр гаргалтыг бүрэн илэрхийлэхгүй юм. Харин төрийн нэрийн өмнөөс албан үүрэг гүйцэтгэх байгаа хэн бүхний оролцоо үүнд чухал нөлөөтэй.

Иймд албан хаагч буюу хууль сахиулагчийн хүний эрхэд суурилсан шийдвэр гаргалт болон шийдвэр гаргах үйл ажиллагааг судлан, шинжлэх хэрэгтэй.

Үндсэн хэсэг

Хүний эрхийн хандлага нь нийгмийн хөгжилтэй салшгүй холбоотой болохын хувьд шийдвэр гаргалт, шийдлийн хувилбаруудыг боловсруулахад хүний эрхийн суурь ойлголт, зарчим, хүний хэрэгцээний асуудал чухал байх суурь эзэлдэг.

“Хөгжил нь нийт иргэд, хувь хүмүүсийн идэвхтэй, чөлөөт оролцоонд үндэслэн нийгэмд бий болж буй үр ашгийг шударгаар хуваарилах, бүх нийтийн сайн сайхан байдлыг хангах зорилго бүхий улс төр, эдийн засаг, нийгэм соёлын цогц үйл явц мөн”¹ гэж тодорхойлж байгаа бөгөөд биет байдлаар оюун санаанд бий болон хэрэгждэг ойлголт юм.

Хөгжлийн хандлагыг халамжид суурилсан, хэрэгцээнд суурилсан, эрхэд суурилсан хэмээн ангилж байна².

Халамжид суурилсан хандлагын шинжүүд:

- Үр дүнд бус өгөгдөхүүнд анхаардаг
- Халамжийг нэмэгдүүлэхийг чухалчилдаг
- Баячууд ядуусыг тэтгэх ёстой гэсэн ёс суртахууны хариуцлагыг дэмждэг
- Бие хүнийг хохирогч гэж хардаг
- Хүмүүсийг тусламж дэмжлэг авах шаардлагатай гэж хардаг
- Асуудлын илрэн гарч буй хэлбэрт анхаарал хандуулдаг.

Хэрэгцээнд суурилсан хандлагын шинжүүд:

- Үр дүнд бус өгөгдөхүүнд анхаардаг
- Хэрэгцээг хангахыг чухалчилдаг

¹ Хүний эрхийн үндэсний комисс. Хүний эрхийн ойлголт, хүний эрхэд суурилсан хандлага. Илтгэл. УБ., 2024. 20 дахь тал.

² Хүний эрхийн үндэсний комисс. Хүний эрхийн ойлголт, хүний эрхэд суурилсан хандлага. Илтгэл. УБ., 2024. 21 дэх тал.

- Хэрэгцээг бодит баталгаа гэж үздэг
- Хувь хүнийг хөгжлийн оролцооны объект гэж үздэг.
- Хүмүүсийг тусламж дэмжлэг авах шаардлагатай гэж хардаг
- Асуудлын шууд шалтгаанд анхаарлаа хандуулдаг.

Эрхэд суурилсан хандлагын шинжүүд:

- Үйл явц болон үр дүнд анхаардаг.
- Эрхийг танин мэдэхийг чухалчилдаг
- Үүрэг хүлээгчдийг эрх зүйн болон ёс суртахууны үүрэг хариуцлагаа хүлээхэд хувь хүний болон бүлгийн эрх чухал баталгаа болно гэж үздэг.
- Эрхээ баталгаатай эдлүүлэхийн тулд хувь хүн болон бүлгийг чадавхжуулах
- Хүмүүсийг тусламж дэмжлэг авах эрхтэй гэж хардаг.
- Суурь шалтгаан болон түүний илрэл дээр анхаарлаа хандуулдаг.

Үүнээс хүний эрхэд суурилсан хандлага нь үйл явцын турш тухайн хүнд тодорхой үйл ажиллагаа, шийдвэр нь хэрхэн нөлөөлөхийг анхаарч, эрхийн мөн чанарыг нэн тэргүүнд авч үздэг байна.

Хөгжлийн гол асуудлууд болох тэгш бус байдал, ялгаварлан гадуурхах практик, эрх мэдлийн шударга бус хуваарилалт зэрэгт дүн шинжилгээ хийж, анхаарал хандуулах замаар хөгжлийг илүү сайн, тогтвортой үр дүнд чиглүүлдгээрээ хүний эрхэд суурилсан хандлага давуутай юм. Мөн энэхүү хандлага, арга зүй нь хоёр талт болон олон талт хөгжлийн байгууллагууд, төр, иргэний нийгмийн байгууллага болон ТББ-ыг хөгжлийн үйл явцад оролцож, хувь нэмрээ оруулах боломжийг олгодог. Хүний эрхэд суурилсан хандлага, арга зүй нь хүнийг эрх-агуулагч болохыг, үүрэг хүлээгчдийн үүрэг хариуцлагыг тогтоох нь зүйтэй болохыг чухалчлан үздэг. Хүний эрхэд дэвшилттэйгээр хүрэхийг зорихын зэрэгцээ аливаа бодлого, хөтөлбөрийн гадна үлдсэн, эрх мэдэл багатай, ялгаварлагдсан бүлгийг онцгойлон анхаардаг бөгөөд хөгжлийн үйл явц, үр дүнд адил ач холбогдол өгдөг онцлогтой юм. Хөгжлөөс үүдэн гарсан шударга бус байдлыг тодорхойлж, ялгаварлан гадуурхсан болон эрх мэдлийн тэнцвэргүй хуваарилалтыг залруулахыг эрмэлздэг.

Хүмүүсийн хэрэгцээ шаардлагыг хангахаас илүүтэйгээр хүний эрхийг хангахад хүний эрхэд суурилсан хандлага арга зүй чиглэж байна. Хэрэгцээ нь хүнийг сэтгэл дундуур байдалд хүргэхийг хүсдэггүй бол эрх нь хүчирхийллийг хүлээн зөвшөөрдөггүй ба тэрхүү эрхийн зөрчлийг хууль ёсоор сэргээхийг шаарддагаараа онцлогтой. Хүний эрхэд суурилсан хандлагыг удирдлага болгох нь эрх оршин байдаг гэдгийг зөвшөөрснөөрөө хэрэгцээнд суурилсан хандлагаас ялгардаг. Энэ нь төр болон үүрэг хүлээгчдийн хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах чадавхыг баталгаажуулдаг байна.

Нэг үгээр бол хүний эрхэд суурилсан хандлага нь эрхийг хэрэгцээтэй холбон илэрхийлдгээрээ онцлогтой.

Тухайлбал хүн бүр сурч боловсрох эрхтэй. Сурч боловсрох эрх нь боломжтой, байх, хүртээмжтэй байх, хүлээн авахуйц байх, амьдралд тохирохуйц байх зэрэг шинжийг өөртөө агуулдаг. Ингэснээр сурч боловсрох эрх, түүнд тавих шаардлагыг ойлгох боломжийг нэмэгдүүлдэг. Эдгээр тухайн эрх ямар байх ёстой гэдэг агуулгыг тодорхойлдог юм.

Харин хэрэгцээ бол байх тухай асуудлыг хөнддөг. Яагаад байх ёстой болохыг тодорхойлдог. Яагаад сурч боловсрох эрх байх ёстой болох агуулгыг хөнддөг. Сурч боловсрох эрхийг хэрэгжүүлснээр мэдлэг эзэмших, түүнийг хэрэгжүүлэх чадвар эзэмшиж, нийгэм, гэр бүлээ өөрчлөх боломжийг нэмэгдүүлдэг¹.

“Тухайн эрх оршин байх ёстой төдийгүй, заавал байх шалтгаантай учраас” хэмээн эрхийг хэрэгжүүлэх үр дүнд чиглэх бус тухайн эрх хэрэгжих үеэс эхлэн үр дүнд хүрэх хүртэл анхаарч шийдвэр гаргадаг хөгжлийн чиг хандлагыг эрхэд суурилсан хандлага гэж үзэж байна.

Хүний эрхийг хангах, хамгаалах, хууль сахиулах ажиллагаанд сүүлийн жилүүдэд нэлээдгүй анхаарал хандуулж байгаа судлагдахуун нь хүний эрхэд суурилсан шийдвэр гаргах, хүний эрхийн хандлагын тухай асуудал болоод байна.

Учир нь хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх нь хуулиар тогтоосон заалт, зохицуулалт хэрэгжсэн байх буюу илүүтэйгээр үр дүнд чиглэсэн байх агуулгатай байна. хууль болон түүнийг хэрэгжүүлэх ажиллагаа нь илүү объектив хүчин зүйлсэд тулгуурласан байдаг бол хандлага нь субъектив хүчин зүйлсийн нөлөөг хууль сахиулагч үнэлэхийг шаарддаг. Энэ нь нийгмийн харилцаа, нийгмийн хөгжлийн гол чиглэл болоод байгааг авч үзэх хэрэгтэй.

Хүний эрхийн хандлага нь тодорхой зарчмуудыг өөртөө агуулдаг². Үүнд дараах зарчмууд хамаарна.

- Түгээмэл, салшгүй байх- Хүний эрх нь дэлхийн өнцөг булан бүрт амьдарч буй хүн бүрт адил тэгш, салшгүйгээр заяагдсан билээ. Хувь хүн сайн дураараа өөрийн эрхээ эдэлж чадахгүй. Үүний адилаар хэн нэгэн үүнийг бусдаас салгаж болохгүй юм. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын нэгдүгээр зүйлд заасанчлан “Бүх хүмүүс нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш, эрх чөлөөтэй төрсөн” билээ. (А1)³

¹ Хүний эрхийн үндэсний комисс. Хүний эрхэд суурилсан хандлага. Сургалтын гарын авлага. УБ., 2016. 86 дэх тал.

² Хүний эрхийн үндэсний комисс. Хүний эрхэд суурилсан хандлага. Сургалтын гарын авлага. УБ., 2016. 80-81 дэх тал.

³ Сургалтад ашиглахад хялбаршуулах зорилгоор “(А1)” буюу товчлол ашиглав.

- Хуваагдашгүй байх- Хүний эрх хуваагдашгүй байна. Иргэний, улс төрийн, эдийн засгийн, соёлын эрх зэрэг олон төрлөөс үл хамааран хүн бүрийн эрхэм чанартай салшгүй холбоотой. Иймээс, эдгээр нь эрх болохынхоо хувьд адил тэгш статустай бөгөөд ямар нэгэн байдлаар зэрэглэн үзэж болохгүй юм. (A2)

- Харилцан хамааралтай, уялдаатай байх- Аливаа нэг эрхийг хангах нь бусад эрхээсээ хэсэгчлэн буюу бүхэлдээ хамаардаг. Тухайлбал, эрүүл байх эрхээ эдлэх нь мэдээлэлтэй байх эрхээс хамаарч болно. (A3)

- Тэгш, үл алагчлах- Аливаа хүн бүр өөрийн төрөлхөөс заяасан эрхэм чанарын хувьд адил тэгш бөгөөд эрх эрх чөлөө нь ямар нэгэн алагчлалгүйгээр тэдэнд заяасан юм. Эрхэд суурилсан хандлага нь алагчлал болон тэгш бус байдлын асуудалд тусгайлан анхаарал хандуулах шаардлагатай байдаг. Хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдэд нийгмээс тусгаарлагдаж буй бүлгүүдийн сайн сайхан байдал, эрхийг хамгаалах асуудлыг тусгах хэрэгтэй байна. Эмзэг бүлгийнхэнд илүү их бололцоог нээхийн тулд мэдээллийг аль болох олон төрлөөр тухайлбал, хүйс, шашин, үндэс угсаа, хэл болон хөгжлийн бэрхшээлтэй эсэх зэргээр нарийвчлах шаардлагатай байна. Хөгжлийн бодлого, шийдвэр, санаачлагууд нь орон нутгийн оршин суугчдыг гэгээрүүлэх арга замыг хайдаг бөгөөд хүчний тэнцвэргүй харилцааг хадгалахын эсрэг тэмцэх буюу дахин шинэ бүтцийг бүрдүүлэхэд зохих хувь нэмэр оруулдаг. (A4)

- Оролцоог хангах, тэгш хамруулах- Хүн бүр эрх, эрх чөлөөгөө эдлэх замаар иргэний, нийгэм, эдийн засгийн, улс төрийн болон соёлын хөгжилд өөрийн хувь нэмрээ оруулах, чөлөөтэй, идэвхтэй, утга учиртай оролцох эрхтэй билээ. (A5)

- Гэгээрэл- Гэгээрэл гэдэг нь хүмүүс өөрсдийнхөө эрхийн төлөө тэмцэх боломжийг бий болгогч үйл явц юм. Хүмүүс өөрт нь чиглэсэн бодлого, хууль шийдвэр болон үйлчилгээг хүлээхээс илүү өөрийн эрхийн төлөө тэмцэх талаар гэгээрүүлэх шаардлагатай. Эдгээр санаачлагууд нь хувь хүмүүс болон нийгмийн бүлгүүдийн хариуцлагатай үйлдэх чадавхыг бүрдүүлэхэд чиглэн ажиллана. Үүний зорилго нь хүмүүст өөрсдийн амьдралыг өөрчлөх, амьдарч буй нийгмээ шинэчлэх, хувь заяагаа мэдэх боломж, хүч чадлыг өгөхөд оршино. (A6)

- Эрх зүйт ёсыг дээдлэх, хариуцлагатай байх- Эрхэд суурилан хөгжих хандлага нь “эрх эдлэгч”, “үүрэг хүлээгч” нарыг уялдуулан үзэх замаар хөгжлийн үйл явц дахь хариуцлагын түвшинг нэмэгдүүлж, үүрэг хүлээгчдийн хариуцлагаа биелүүлэх бололцоог дээшлүүлдэг. Үүнд хүний эрхийг хангах, хамгаалах, хүндэтгэх болон хүний эрхийг зөрчихөөс татгалзах зэрэг эерэг, сөрөг бүхий л үүрэг хариуцлагыг багтаан ойлгоно. Засгийн газрын хувьд хувь хүн, орон нутгийн байгууллага, албан тушаалтнууд, хувийн хэвшил, хэвлэл мэдээлэл, ивээн тэтгэгчид болон хөгжлийн түншлэгчид, олон улсын байгууллагууд зэрэгтэй харьцуулахад хүний эрхийг хэрэгжүүлэх талаар бусад оролцогчдоос илүү өргөн цар хүрээ бүхий үүрэг хариуцлага хүлээлгэдэг. Харин олон улсын хамтын нийгэмлэгийн хувьд нөөц болон чадавхын хувьд хязгаарлагдмал хөгжиж буй орнуудтай үр дүнтэй хамтран ажиллах үүрэг ноогддог. Эрхэд суурилан хөгжих хандлага нь хүн бүрийн хувьд

зөрчил, үгүйсгэлээс хамгаалагдах, эрхээ бүрэн эдлэхүйц эрх зүй, захиргааны практик, механизм, тогтолцоог хөгжүүлэхийг шаарддаг. Мөн олон улсын нийтлэг хэм хэмжээг орон нутгийн түвшинд нийцүүлэн хариуцлагыг дээшлүүлэх, дэвшлийг хэмжих үлгэр загвар буюу шалгуурыг (бенчмарк) бий болгохыг шаардана. (А7)

Дээрх зарчмууд нь хууль хэрэгжүүлэгч этгээдээс иргэдтэй харилцахдаа заавал баримтлах зарчим бөгөөд хүний эрх нь түгээмэл салшгүй гэдгийг ухамсарлан аль нэг эрхийг нөгөөгөөр нь орлуулах, дур мэдэн хязгаарлах, нэг эрхийг хэрэгжүүлсэн боловч нөгөө эрхийг хэрэгжүүлэх боломжийг хязгаарлан хясан боогдуулах, хуулийн хүрээнд ижил боломжоор хангах агуулгыг илэрхийлдэг.

Мөн хууль хэрэгжүүлэгч этгээд нь тухайн харилцаанд оролцогдчын оролцоог бүрэн нээлттэй хангах, соён гэгээрүүлэх үүргийг хүлээх шаардлагатай. Ингэснээр хүний эрхийг тэгш хүртээмжтэй хангах, эрх зүйн хэрэглээ, эрх зүйн ач холбогдлыг тайлбарлан таниулж, эрхийн хязгаарлалтын ач холбогдлыг харилцагч иргэдэд ухамсарлуулан өөрөөр нь хүлээн зөвшөөрүүлэх боломж олгох юм.

Эдгээр нь хүний эрхэд суурилсан хандлагын үндсэн агуулга бөгөөд эдгээр нь үр дүнд бус процесст илүү анхаардаг бөгөөд хууль тогтоомж нь өөрөө үр дүнт тодорхойлдог болохыг ямагт санах хэрэгтэй.

Хүний эрхэд суурилсан шийдвэр гаргалт:

Хүмүүс өдөр бүр олон янзын шийдвэр гаргадаг. Эдгээр шийдвэрийн зарим нь ямар хувцас өмсөх, үдийн хоолон дээрээ юу идэх гэх мэт харьцангуй жижиг зүйл байхад зарим нь бидний амьдралд арай чухал нөлөө үзүүлэхүйц их сургуульд ямар мэргэжлээр суралцах, ямар хүнтэй гэрлэх, тамхи татаж эхлэх эсэх, бэлгийн харилцаанд хэзээ, хэнтэй орох гэх мэт байж болно. Гэсэн хэдий ч илтэд энгийн буюу чухал биш шийдвэр нь ч гэсэн тодорхой нөхцөл байдалд чухал ач холбогдолтой байж болох ба улмаар шийдвэр гаргах чадвар сайтай байх шаардлагатай болдог. Жишээ нь, хэрвээ чи ажил олгох хүнтэй уулзах гэж байгаа бол өмсөх хувцсандаа анхаарах шаардлагатай болно. Мөн эрүүл мэндийн байдлаасаа хамаарч идэх хоолоо сонгохдоо ч анхаарал тавих шаардлага гарна гэх мэт.

Харин хууль хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шийдвэр гаргах нь нөгөө талд хүний эрхийн хязгаарлалт, хүний эрхийн зөрчил болдог тул онцгой анхаарах шаардлагатай.

“Шийдвэр” гэж асуудлыг үүсгэж буй шалтгааныг арилгах эсвэл тодорхой зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дүгнэлтэд үндэслэн гаргасан шийдэл¹ хэмээн тодорхойлсон байна. үүнээс авч үзвэл тухайн шийдвэрийг гаргахын тулд хууль

¹ Хүний эрхийн үндэсний комисс. Монгол улсын үндсэн хуулийн хоёрдугаар бүлэгт туссан хүний эрхийн заалтуудад системийн инженерчлэлийн аргаар тодорхойлолт боловсруулах нь. Судалгаа. УБ., 2024. 59 дэх тал.

хэрэгжүүлэгч этгээд нь тодорхой хүчин зүйлс, шалгууруудыг үндэслэн дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах явдлыг ойлгож болохоор байна. Тэгвэл хүний эрхэд суурилсан шийдвэр гаргалт нь хүний эрхэм чанар, хүний эрхийн зарчмуудыг удирдлага болгон тэдгээрт үндэслэн хуульд заасан шийдвэр гаргах, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх хүний эрхэд суурилсан шийдвэр гаргалтын үндсэн агуулга гэж үзэж болно.

Энэ нь нэг үгээр бол хууль хэрэгжүүлэг аливаа нөхцөл байдалд хүний эрхэм чанар, хүний эрхийн зарчим, хүний эрхийн хандлагыг удирдлага болгон хуульд заасан хэм хэмжээг сонгон хэрэглэх явдал бөгөөд тухайн шийдвэр нь хүний оролцоог хангасан, ойлгомжтой, үндэслэлтэй, соён гэгээрүүлэх агуулгыг илэрхийлсэн байх ёстой.

Хүний эрхэд суурилсан шийдвэр гаргалтад хууль ёсны байх зарчим хамгийн чухал нөлөөтэй хэдий ч шийдвэр гаргалт нь менежментийн шинжлэх ухааны судлагдахуун болдог тул менежментийн суурь үзэл санааг хүний эрхэм чанар, хүний эрхийн зарчмуудтай уялдуулан авч үзэх нь оновчтой.

Шийдвэр гаргалт бол хэд хэдэн боломжит хувилбаруудын дундаас итгэл үнэмшил, үйл ажиллагааны чиглэлээс шалтгаалан сонгоход хүргэж байгаа танин мэдэхүйн үйл явц юм. Харин тэрхүү боломжит шийдвэр гаргахад баримтлах зарчмуудыг хүний эрхэд суурилсан хандлагаар шийдвэр гаргагч заавал мэдэх ёстой.

Хүний эрхийн салбарт нийтлэг хэрэглэгддэг зарчим бол “PANEL”-ийн зарчим юм.

Participation – тухайн хүний эрхийг хөндсөн шийдвэр гаргахдаа тухайн этгээдийн оролцоог хангасан байх буюу шийдвэр гаргалтад оролцох боломжийг хангах;

Accountability – хариуцлагатай байх зарчим. Энэ нь шийдвэр гаргагчаас хүний эрхийн олон улсын болон дотоод эрх зүйн хэм хэмжээг мөрдөх бөгөөд хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, арилгах зэрэг механизмыг хэрэгжүүлэх агуулга юм.

Non-discrimination and Equality – хүний хувийн болон нийгмийн шинжээр нь ялгаварлан шийдвэр гаргахаас урьдчилан сэргийлж бүх хүмүүст ижил боломжийг олгох ёстой.

Empowerment – хүн бүр эрхээ хэрэгжүүлэхээр шаардах боломжтой байх. Хувь хүн болон бүлэг хүмүүс тэдний эрхийг ойлгож хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.

Legality – хуулиар хүний эрх, эрх чөлөөг хамгаалдаг, хууль тогтоомж нь хүний эрхийн зарчмуудыг агуулсан байх ёстой.¹ Ингэснээр шийдвэр гаргагч нь шийдвэр гаргахдаа тухайн этгээдийн оролцоог хангаж, тэгш-ялгаварлан гадуурхахгүй хандах ба тэднээс эрхээ шаардах боломжийг хүлээн зөвшөөрч, аливаа зөрчилд хариуцлага хүлээлгэдэг байдлаар илэрнэ.

Ийнхүү хүний эрхэд суурилсан хандлагад тавигдах нийтлэг зарчим, шалгууруудыг эзэмшсэн хууль сахиулагчийг бэлтгэхэд бакалаврын сургалтын хөтөлбөрийн агуулга, хичээлүүдийн агуулгад хүний эрхэд суурилсан хандлагаар дүн шинжилгээ хийх, төлөвлөх, сайжруулж, дүн шинжилгээ хийх боловсролын байгууллагын хүлээх үндсэн үүрэг болж байна.

Хүний эрхэд суурилсан шийдвэр гаргалт нь хууль хэрэгжүүлэгч этгээдээс тухайн хэм хэмжээ, хязгаарлалт нь хүний эрхэд хэрхэн нөлөөлөхийг үнэлсний үндсэн дээр боломжит сонголтуудаас хүний эрхэм чанарыг хүндэтгэсэн хувилбарыг сонгож хэрэгжүүлэхийг ойлгоно. Энэ нь хууль хэрэгжүүлэгчээс авч хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээ, эрхийн хязгаарлалтууд нь оролцогч этгээдийн эрхэд хэрхэн нөлөөлөх байдлыг үнэлэх, таамаглах байдлаар шийдвэр гаргах арга хэмжээ юм.

Шийдвэр гаргах талаар зохих чадвар эзэмшээгүй байх, эсвэл яарч шийдвэр гаргаснаар тухайн асуудалтай холбоотой байгаа бусад хүчин зүйлийг харгалзан үзэлгүй тааруухан шийдвэр гаргахад хүрч, улмаар тухайн хүн эцэстээ өөрөө харамсаж мэдэх үр дагавар бүхий нөхцөл байдалд орчихсон байх магадлалтай.

Нөгөө талаасаа сайн шийдвэр гаргах чадвар нь шийдвэр гаргах үйл явцад өөрөө идэвхтэй оролцох, цаг хугацаагаа зөв сонгох, бүтээлч байх боломжийг хүнд олгодог. Аль шийдвэр нь чухал ач холбогдолтой, аль нь илүү анхаарах шаардлагатай, аль нь арай бага хүчин чармайлттайгаар шийдвэрлэж болох асуудал вэ гэдгийг тогтооход шийдвэр гаргах чадвар нэн чухал шаардлагатай. Шийдвэр гаргах чадвар сайтай хүн шийдвэрийг гаргааа хойшлуулах, түүнээс зайлсхийх зэрэг алхам хийдэггүй. Тэд өөрт нь байгаа хувилбарт сонголтуудаас гарч болох үр дагавруудыг жагсаан бичээд дүн шинжилгээ хийж, эдгээр үр дагаврын тохиолдох магадлалд үнэлгээ дүгнэлт өгөхдөө өөрсдийнхөө мэдрэмж болон эрхэмлэдэг үнэт зүйлсийг тооцож чаддаг. Тэдний гаргасан шийдвэр нь бодит хүлээлт дээр тулгуурласан, өөрсдийнх нь үзэл бодол, үнэт зүйлтэй нийцсэн байдаг ба тэд нэгэнт гаргасан шийдвэрээ бусад хүний нөлөөнд авталгүйгээр хэрэгжүүлэх чадвартай байдаг.

Тухайн нөхцөлд байж болох хувилбарт сонголт хийх түүний үр дагавар нь сонголт тус бүрийн давуу болон сул талыг тооцоолохын зэрэгцээ өөрийн эрхэмлэдэг үнэт зүйл, төрж буй дотоод мэдрэмжийг цэгнэж үзэх боломжийг хууль

¹ <https://humanrights.gov.au/Human> rights based approaches

хэрэгжүүлэгчээс шаардана. Өөрийн ирээдүйн төлөвлөгөө, зан үйлийнхээ талаар, эсвэл бусад хүнтэй тогтоосон холбоогоо хэрхэн зохицуулах талаар сонголт хийхэд энэхүү сэдэв тус нэмэр болно. Иймд хууль хэрэгжүүлэгчийн шийдвэр гаргах чадварыг хөгжүүлэх нь чухал байна. Ялангуяа иргэдийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч шийдвэр гаргах нь алба хаагчийн хувьд чухал төдийгүй төрийн өөрийн чиг үүргээр хариуцлага хүлээх нь хүний эрхэд суурилсан шийдвэр гаргалтыг өргөжүүлэх ач холбогдолтой.

Төрийн үүрэг хариуцлагыг 3 хэсэгт авч үзэж байна¹.

Тэгвэл шийдвэр гаргалтад тодорхой шинжүүдийг зайлшгүй авч үзэх шаардлагатай бөгөөд эдгээр нь шийдвэр гаргах чадварыг хөгжүүлдэг байна. Харин хүний эрхэм чанар, хүний эрхийн зарчим, хандлагыг шийдвэр гаргах шинжүүдэд баримтлах нь хүний эрхэд суурилсан шийдвэр гаргах үндсэн нөхцөл болно. Үүнд:

- Мэдээллийн хүртээмжтэй байдал. Энэ нь тухайн шийдвэр гаргахад нөлөөлж байгаа үндсэн мэдээлэл нь тухайн харилцаанд оролцогчдод жигд хүртээмжтэй байх ёстой. (B1)²

- Шийдвэр гаргалтын хугацаа. Энэ нь шийдвэр гаргах боломжит хугацааг илэрхийлсэн ойлголт бөгөөд тодорхой хугацаа нь шийдвэр гаргалтын хурдан, нарийвчлалтай гаргах нөлөөлдгийг санах хэрэгтэй. (B2)

- Эрсдэл ба тооцоолоогүй нөхцөл байдал. Тухайн шийдвэрээс гарч болох эрсдэлийг таамаглах шаардлагатай бөгөөд тооцоолоогүй нөхцөл үүсэхээс аль болох сэргийлэх. (B3)

- Зорилго. Шийдвэр нь тооцоолсон эсхүл эерэг үр дүнд хүрэх ёстой. Тооцсон үр дүндээ чухлыг эрэмбэлэх хэрэгтэй. (B4)

- Хувийн болон байгууллагын үнэт зүйлийг харгалзан үзэх. Энэ нь алба хаагч болон хууль сахиулагчийн хувьд үйл ажиллагаандаа баримтлах хүний эрх, үндсэн хуулийн зарчмууд байж болно. (B5)

- Нөөц боломжоо үнэлэх. Санхүүгийн болон бусад шаардлагатай нөөцүүдийг үнэлэх. (B6)

- Гадаад орчны нөлөөлөл. Нийгэм болон хууль эрх зүйн хувьд таны гаргасан шийдвэр нь хүлээн зөвшөөрөгдөж чадах эсэхийг үнэлэх хэрэгтэй. (B7)

- Туршлага. Шийдвэр гаргагч этгээдийн энэ төрлийн болон бусад харилцаанд хэрхэн оролцож шийдвэр гаргаж байсан туршлагыг хамааруулна. (B8)

- Сэтгэл хөдлөлийн хүчин зүйлс. Нийгмийн тодорхой харилцаанд оролцогч нь тухайн нөхцөл байдлаас хамаарч сэтгэл хөдлөлийн түвшин харилцан адилгүй байх бөгөөд хэвийн сэтгэл хөдлөлтэйгөөр шийдвэр гаргахыг эрмэлзэх. (B9)

- Сонголтын хувилбар. Хамгийн сайн бөгөөд оролцогч талуудын хэн хэний ашиг сонирхлыг дэмжих хувилбарыг сонгох, эрэлхийлэх. (B10)

¹ A human rights based approach. Manual. 2021

² Сургалтад ашиглахад хялбаршуулах зорилгоор “(B1)” буюу товчлол ашиглав.

- Урт болон богино хугацааны үр дүн. Таны гаргасан шийдвэр урт, богино хугацаанд таны төсөөлсөн эсвэл, тооцоолоогүй ямар үр дүнд гаргах, хэрхэн нөлөөлөхийг тооцоолох шаардлагатай. (B11)

Дээрх шинжүүд нь шийдвэр гаргахад анхаарах үндсэн нөхцөлүүд бөгөөд эдгээр нөхцөлүүдийг үнэлэх ерөнхий шалгуур нь хүний эрхэм чанар, хүний эрхийн зарчим байдаг. Ингэснээр тухайн шийдвэр нь хүний эрхэд суурилсан, хүний эрхийг дэмжсэн шийдвэр болох боломжтой.

Эдгээрийг анхан шатны буюу үйл ажиллагааны түвшний шийдвэр гаргалтад өргөн ашиглах нь хууль сахиулах үйл ажиллагаанд хүний эрхийг хангах, эрхэд суурилсан шийдвэр гаргалтын гол нөхцөл болно.

Тухайлбал менежментийн шинжлэх ухаанд шийдвэр гаргалтын үе шатуудыг тодорхойлсон байдаг ба уг үе шатуудыг гүйцэтгэхдээ хичээлийн нэгдүгээр хэсэгт дурдсан хүний эрхийн хандлагын зарчмуудыг баримтлах шаардлагатай.

Үүнд дараах үе шат хамаарна.


- Асуудлыг тодорхойлох
- Шийдвэрийн хувилбаруудыг боловсруулах
- Хувилбарыг үнэлэх
- Сонголт
- Үр дүнг тооцох

Тухайлбал:

Эрүүгийн хэрэг хянан, шийдвэрлэх тухай хуульд “цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ”-г авах үндэслэлүүдийг заасан байдаг бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас оргон зайлахыг завдсан, эсхүл оргон зайлсан гэх үндэслэлийг заасан байна.

Үүнийг авч үзвэл дээрх үйлдэл нь завдсан, эсхүл оргон зайлахыг завдсан үр дүн байх бөгөөд тухайн үр дүнд шууд авч хэрэгжүүлэх боломжтой хүний эрхийн хязгаарлалт тогтоох зохицуулалт юм. Харин хүний эрхийн хандлага нь тухайн этгээд оргон зайлахыг завдах эсхүл оргон зайлах хүртэл процесст хамаарах ойлголт бөгөөд эрүүгийн хэрэг үүсгэхээс эхлэн тухайн этгээдийг цагдан хорих шийдвэрийг гаргах хүртэл хугацаанд хууль сахиулагчийн зүгээс хүний эрхэм чанар, хүний эрхийг дээдлэх зарчмын хэрэгжилтээр тодорхойлогдох юм. Хэрэв гэмт этгээд оргон зайлах хүртэл процессын турш хүний эрхэд суурилсан хандлагаар шийдвэр гаргаж ажилласан бол заавал хүний халдашгүй байх эрхэд ноцтой халддаг цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэхгүй байх боломж үүснэ.

Эцэст хүний эрхэд суурилсан шийдвэр гаргалт дараах үе шатыг дамжина.



Эдгээрээс үзвэл хүний эрхэд суурилсан шийдвэр гаргалт нь аливаа шийдвэрийг хүний эрхийг хангах төдийгүй хүний хэрэгцээг бүрэн илэрхийлэх боломжтойгоор гаргах бөгөөд шийдвэр гаргах үе шатанд бусдын оролцоог хангах, оролцох боломжийг бүрдүүлсэн, эрхийн зөрчилгүй байх буюу үр дүн болон үр дүнд хүрэх үе шатуудад хүний эрхийг эрхэмлэсэн үйл ажиллагааг хамааруулж болно.

ДҮГНЭЛТ

1. Дэлхийн улс орнуудын туйлын ашиг сонирхол нь тухайн улсын хөгжил, цэцэглэлтэд төвлөрч байна. харин хөгжлийг гол үзэл санаа нь ард иргэдийн ашиг сонирхол, хэрэгцээг хангахад чиглэгддэг ажээ. Учир нь хүний эрх, хүний хэрэгцээнд суурилаагүй хөгжлийн бодлого, үзэл баримтлал нь үр дүнгүй, тогтворгүй болохын нийгмийн гишүүдийн оролцоог бүрэн хангаж чадахгүй.

2. Хүний эрхэд суурилсан хандлага нь тодорхой зорилгод хүрэхийн эрмэлздэг хэдий ч тэрхүү зорилгод чиглэсэн арга хэмжээ, үйл ажиллагаа нь бүрийн хүртээмж, үр өгөөжид төвлөрдөг байна. нэг үгээр хэлбэр үр дүн чухал хэдий ч тэрхүү үр дүнд хүрэх арга зам нь ч мөн адил хүний эрхэд суурилсан байх ёстой болохыг илэрхийлж байна.

3. Хууль сахиулах үйл ажиллагаа нь хэдийгээр хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэх, сахин хамгаалах үйл ажиллагаа боловч эрх зүйн онол, үзэл хандлагын үүднээс авч үзвэл хүний эрхийг зохистойгоор хангах, хамгаалах чиглэсэн арга хэмжээ болохыг илэрхийлж байна. мөн хууль сахиулах үйл ажиллагааг хүний эрхэд суурилсан хандлага, алба хаагчийн хүний эрхэд суурилсан шийдвэр гаргалтын байдлаар авч үзвэл хууль, тогтоомжийг хүний эрхэд суурилсан байдлаар боловсруулах шаардлагатай үндсэн судалгааны эх сурвалж болох нь харагдаж байна.

4. Хууль сахиулагчийн шийдвэр гаргалтын үе шат болон шалгуур үзүүлэлтүүдийг оновчтой тодорхойлж, алба хаагчдад санал болгох нь хүний эрхэд суурилсан хууль сахиулах ажиллагааг хөгжүүлэх суурь хүчин зүйл болж байна. Энэ хүчин зүйлсийн гол агуулга нь иргэдийн эрх, эрх чөлөөг хүндэтгэж, оролцоог нь хангаж, зөрчилдөөнийг эергээр шийдвэрлэх зорилготой болохыг тодорхойлж байна.